



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2018 ОНЫ  
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ  
НАГ-/2019/06/-НА



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ  
АРГА ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

Чойбалсан хот  
2019 он

Тайланг бэлтгэсэн:  
Дорнод аймаг дахь  
Төрийн аудитын газрын

Дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Б.Болортуул  
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер  
В.Цэнгэлмаа  
Утас: 70584204

Нийцлийн аудитын  
албаны Аудитор  
Б.Батжаргал,  
Б.Одхүү  
Гэрээт аудитор  
Г.Хонгорзул  
Утас: 70584207

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал 7058-  
4204, 7058-4207 дугаарын  
утас болон  
[www.dornod@audit.gov.mn](mailto:www.dornod@audit.gov.mn)  
цахим хаягаар  
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,  
Хэрлэн сум, 7-р баг,  
АЗДТГ-ын 2-р байр,  
1 давхар 02 тоот

## Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга

**I Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сумдад олгох орлогын шилжүүлгийг яамнаас хуваарилсан байна.**

1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас сумд үйлчилгээний зардлыг хэрхэн хуваарилаа журам, зааварт тодорхой заасан зох байхгүй байна.

**II Бүлэг. Орон нутгийн хөгжлийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга х төлөвлөж, зарцуулсан байна.**

2.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигд хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхд тогтоомж, зааврыг баримтлаагүй байна.

2.2 ОНХС-гийн хөрөнгөөр санхүү хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгж сумдад холбогдох хууль тогтоомжийг ба зарцуулаагүй байна.

**III Бүлэг. Орон нутгийн хөгжлийн хөрөнгийн зарцуулалтад тавих х бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжү хөтөлбөр, төсөл, арга хэмжээний те санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тави хангалтгүй байна.

3.2. ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг яаманд хүргүүлсэн байна.

**ДҮГНЭЛТ**  
**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН**  
**ЗӨВЛӨМЖ**  
**ТУШААЛ**  
**ТӨЛБӨРИЙН АКТ**  
**АЛБАН ШААРДЛАГА**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|                 |                                                      |
|-----------------|------------------------------------------------------|
| <b>АДБОУС</b>   | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт     |
| <b>ҮАГ</b>      | Үндэсний аудитын газар                               |
| <b>ИТХ</b>      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                         |
| <b>МУ</b>       | Монгол Улс                                           |
| <b>ЗГ</b>       | Засгийн газар                                        |
| <b>НАГ</b>      | Нийцлийн аудитын газар                               |
| <b>НА</b>       | Нийцлийн аудит                                       |
| <b>ОНХНС</b>    | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан                    |
| <b>ОНХС</b>     | Орон нутгийн хөгжлийн сан                            |
| <b>СЯ</b>       | Сангийн яам                                          |
| <b>ЗДТГ</b>     | Засаг даргын тамгын газар                            |
| <b>СС</b>       | Сангийн Сайд                                         |
| <b>ОНӨААТҮГ</b> | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| <b>СТСХ</b>     | Санхүү төрийн сангийн хэлтэс                         |
| <b>ААН</b>      | Аж ахуй нэгж                                         |
| <b>ХБТХ</b>     | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс                 |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:**

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх,

**Аудитын хамрах хүрээ:**

Аудитад аймаг, сумдын ОНХС-гийн 2018 оны төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт, гүйцэтгэл, хяналт, тайлагналыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, Санхүүгийн хяналт, аудитын алба, багийн засаг дарга, ИНХ-ыг хамрууллаа.

**Үндсэн мэдээлэл:**

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байсныг 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс Сангийн сайдын 228 дугаар тушаалаар батлагдсан “орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулахаар өөрчилсөн байна.

Улсын төсвөөс 2018 онд Дорнод аймгийн ОНХС-д 3650,4 сая төгрөг хуваарилсан байна.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ Нийцлийн аудитын стандарт (АДБОУС 4000), Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан

“Нийцлийн аудитын түр журам”, аудитын арга зүйд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, санал асуулга авах, шалгадагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

#### **Хууль**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

#### **Засгийн газрын тогтоол:**

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал /2012 оны №30/
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал /2017 оны №230/

#### **Сангийн Сайдын тушаал:**

- Орон нутгийн хөгжлийн сангийн заавар /2014 оны №43/
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам /2018 оны №228/

Холбогдох бусад хууль эрх зүйн актууд

### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж нийцлийн аудитын албаны аудитор Б.Батжаргал, Б.Одхүү, гэрээт аудитор Г.Хонгорзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

### **Аудитын хугацаа:**

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эхэлж 04 дүгээр сарын 10-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж УАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

### **Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Тэргүүлэх аудиторовын тушаалаар батлууллаа.

## I Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Сангийн яамнаас хуваарилсан байна.


Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 3650,4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2018 оны 03-р сарын 23-ны өдрийн ИТХ-аар ОНХНС-гаас 2804,2 сая төгрөг, тогтвортой амьжиргаа - 3 төслөөс 846,2 сая төгрөг, гадаад дотоодын хандив тусламжаар 576,1 сая төгрөг, урд оны үлдэгдлээс 361,8 сая төгрөг нийт 4588,3 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөсөн байна.

ОНХС-гийн хөрөнгийг дараах байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд: ОНХНС-гаас 2804,2 сая төгрөг, тогтвортой амьжиргаа - 3 төслөөс 846,2 сая төгрөг, гадаад дотоодын хандив тусламжаар 293,2 сая төгрөг, урд оны үлдэгдлээс 361,8 сая төгрөг, ОНТ-ийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 27,9 сая төгрөг, нийт 4333,3 сая төгрөгөөр бүрдүүлсэн байна.

ОНХС-гийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:

График 1



Гадаад дотоодын хандив тусламжийн санхүүжилт төлөвлөснөөс 283,0 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн талаар Төсвийн тухай хуулийн 59.2.1-д “энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх”, 59.2.2-т “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэж заасан.


ОНХНС-гаас олгосон орлогын шилжүүлгийг дээрх заалтын дагуу хуваарилсан эсэхийг үзэхэд нийт шилжүүлгээс суманд 41,3 хувь буюу 1630,5 сая төгрөг, аймагт 58,6 хувь буюу 2313,2 сая төгрөгийг хуваарилж олгосон нь хуульд заасан хувь хэмжээнд нийцэж байгаа хэдий ч үйлчилгээний зардалд ногдох хэсэг болон үлдэх

хувиас хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзсан хуваарилалтыг хэрхэн хийсэн нь тодорхойгүй байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон төсвийн мэргэжилтэн сумдад олгох хуваарилалтыг Сангийн яамнаас хийж ирүүлсэн гэсэн тайлбарыг өгч байгаа нь Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна” гэж заасантай нийцэхгүй байна.

ОНХС-гийн нийт орлогыг аймаг, суманд хуваарилсныг графикаар харуулбал:

График 2



Сангийн Яамнаас ОНХС-гаас аймагт шилжүүлсэн орлогын шилжүүлгийг аймаг сумдын ОНХС-нд дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт 1

| Сумдын нэр  | Аймгаас олгосон ОНХС санхүүжилт /сая.төг/ | /тогтвортой амьжиргаа-3 төсөл/ /сая.төг/ | Үйлчилгээний зардал /сая.төг/ | ОНХС нийт дүн /сая.төг/ | Гадаад дотоодын хандив /сая.төг/ | Бүгд ОНХС /сая.төг/ |
|-------------|-------------------------------------------|------------------------------------------|-------------------------------|-------------------------|----------------------------------|---------------------|
| Баяндун     | 44.6                                      | 54.1                                     |                               | 98.7                    |                                  | 98.7                |
| Баянтүмэн   | 22.9                                      | 27.7                                     |                               | 50.7                    | 12.7                             | 63.3                |
| Баян-Уул    | 59.1                                      | 71.6                                     |                               | 130.7                   |                                  | 130.7               |
| Булган      | 21.6                                      | 26.2                                     |                               | 47.9                    |                                  | 47.9                |
| Гурванзагал | 20.9                                      | 25.3                                     |                               | 46.1                    | 6.0                              | 52.2                |
| Дашбалбар   | 49.6                                      | 60.1                                     |                               | 109.7                   |                                  | 109.7               |
| Матад       | 61.6                                      | 74.6                                     | 36.6                          | 172.8                   |                                  | 172.8               |
| Халхгол     | 96.3                                      | 116.7                                    | 36.7                          | 249.7                   |                                  | 249.7               |
| Хөлөнбуйр   | 21.2                                      | 25.7                                     |                               | 46.9                    |                                  | 46.9                |
| Сэргэлэн    | 19.0                                      | 25.8                                     |                               | 44.8                    |                                  | 44.8                |
| Цагаан-Овоо | 39.2                                      | 47.5                                     |                               | 86.7                    |                                  | 86.7                |

|              |        |       |       |        |       |        |
|--------------|--------|-------|-------|--------|-------|--------|
| Чойбалсан    | 31.3   | 37.9  |       | 69.2   | 17.2  | 86.5   |
| Чулуунхороот | 33.4   | 46.1  |       | 79.5   |       | 79.5   |
| Хэрлэн       | 154.2  | 206.7 |       | 360.9  |       | 360.9  |
| Сумдын дүн   | 675,1  | 846.2 | 73.3  | 1594.6 | 35.9  | 1630.5 |
| Аймаг        | 1575.2 |       | 480,6 | 2055.8 | 257.3 | 2313.1 |
| Нийт дүн     | 2250.3 | 846.2 | 553,9 | 3650.4 | 293.2 | 3943.7 |

Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсэг болох 553,9 сая төгрөгийг аймгийн болон Халхгол, Матад сумдын ОНХС-д хуваарилсан байна. Үйлчилгээний зардалд ногдох хэсгийг хэрхэн хуваарилах талаар журам зааварт тодорхой заасан зохицуулалт байхгүй байна.

Хөлөнбуйр сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27,9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 42.3 дахь “Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ”, 43.3.1 дэх “төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, 60.2 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ...” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

## **II Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан байна.**

2.1 *Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталсан уу?* ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх зарим хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй байна.

Сумдын Засаг даргын Тамгын газрын иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийж, эрэмбэлэх ажил хангалтгүй байна. Үүнд:

Хөлөнбуйр, Матад, Чулуунхороот, Чойбалсан, Баян-Уул, Баяндун, Хэрлэн сумдад санал асуулгад оролцсон иргэдийн ирцийн бүртгэл байхгүй, санал асуулгын хуудсыг иргэдийн өмнөөс нэг хүнээр олон удаа бөглүүлсэн, саналын хуудсанд гарын үсэг зуруулаагүй зэрэг нь Сангийн Сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т заасан шаардлагыг хангахгүй байна. Сумдын ЗДТГ нь саналыг журмын дагуу авсан эсэх талаар дүн шинжилгээ хийдэггүй, эрэмбийг зөвхөн саналын тоог харгалзан хийж байгаа нь хангалтгүй байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар нийт 8 сумын 160 иргэнээс ҮАГ-аас ирсэн санал асуулгын маягтын дагуу санал асуулга авлаа. Санал асуулгад оролцогсдын 74,8 хувь нь ОНХС-гийн талаарх мэдээлэл хангалтгүй, 74,1 хувь нь санал өгөх ажиллагаанд оролцож байгаагүй гэсэн хариултыг өгсөн. Энэ нь санал өгөх үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх сул, мэдээлэл өгөх байдал хангалттай хийгдэхгүй мөн Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 5.3-т заасан “Баг, хорооны Засаг дарга Нийтийн хурлын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрд хүргэж, зар хүлээн авсан гарын үсгийг айл өрх бүрээс авч баталгаажуулах ажил хангалтгүй хийгдэж байгааг харуулж байна.

Цаашид ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлыг төлөвлөхдөө олон нийтийн оролцоог бүрэн хангаж, иргэдийн саналыг үнэн бодитой тусгахад анхаарах шаардлагатай байна.

Сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад тусгагдаагүй ажлуудад 6,2 сая төгрөгийг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Матад суманд фитнес байр тохижуулахад 1,2 сая төгрөг, Задгай талбайн тайзны засвар хийхэд 1,5 сая төгрөг,
- Дашбалбар суманд ахмадын байрны халаалтын зуух хийхэд 1,5 сая төгрөг,
- Булган суманд цэцэрлэгт гэр худалдан авахад 2,0 сая төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, 63 дугаар зүйлийн 63.2 “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн санал аваагүй нийт 154,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна. Үүнд:

## Хүснэгт 2

| д/д | Төсөл, арга хэмжээ                                                                                                                                                                      | Мөнгөн дүн<br>/сая.төг/ |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| 1   | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах байрны, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Хүүхэд хөгжлийн төв”-д дэмжлэг үзүүлэх | 10.0                    |
| 2   | “Аз жаргал” төвийн үйл ажиллагаанд дэмжлэг                                                                                                                                              | 5.0                     |
| 3   | Тэжээлийн доройтолтой болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийг хүүхдийн зуслан, сувилал түшиглэн асарч, сувилах төсөл                                                                          | 24.5                    |
| 4   | “Хүн болох багаасаа” дэд хөтөлбөр                                                                                                                                                       | 5.0                     |
| 5   | “Гэр бүлийн хөгжил дэвшил” /2018-2020 он/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх                                                                                                                       | 10.0                    |
| 6   | Хүүхдэд ээлтэй засаглал-2020 хөтөлбөр                                                                                                                                                   | 10.0                    |
| 7   | Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр                                                                                                                                      | 10.0                    |
| 8   | Хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө                                                                                 | 79.6                    |
|     | <b>Дүн</b>                                                                                                                                                                              | <b>154.1</b>            |

Эдгээр төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 60.11-д заасан санал авах шаардлагагүй төсөл, арга хэмжээнд хамаарахгүй бөгөөд мөн 114,6 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь ОНХС-гаас санхүүжүүлж болох хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй байна. Үүнд:

Хүснэгт 3

| д/д | Төсөл, арга хэмжээ                                                                                      | Мөнгөн дүн<br>/сая.төг/ |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| 1   | “Хүн болох багаасаа” дэд хөтөлбөр                                                                       | 5.0                     |
| 2   | “Гэр бүлийн хөгжил дэвшил”/2018-2020 он/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх                                        | 10.0                    |
| 3   | Хүүхдэд ээлтэй засаглал-2020 хөтөлбөр                                                                   | 10.0                    |
| 4   | Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр                                                      | 10.0                    |
| 5   | Хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө | 79.6                    |
|     | <b>Дүн</b>                                                                                              | <b>114.6</b>            |

2.2 Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж зарцуулсан уу? ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ сумдад холбогдох хууль тогтоомжийг баримталж зарцуулаагүй байна.

ОНХС-гийн хууль, журам, зааварт нийцэхгүй арга хэмжээнд зарцуулсан дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Булган сумын ОНХС-гийн хөрөнгөөр “Хашаажуулах төсөл” ажлаар сумын айл өрхүүдэд нийт 10000,0 мянган төгрөгийн хашааг үнэ төлбөргүй олгосон байна.
- Хөлөнбуйр сумын ОНХС-гийн хөрөнгөөр орон сууцны барилга байгууламж хувь хүмүүст эргэн төлөх нөхцөлөөр олгосноос хугацаа хэтэрсэн, төлөгдөөгүй зээлийн 44890,0 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Мөн сумын ИТХ-аар батлагдсан ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдан батлаагүй, иргэдийн саналыг аваагүй ажилд нийт 3269,6 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Баяндун сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Халуун усны засвар”-ын ажлын төсвөөс 1500,0 мянган төгрөгийг батлагдсан арга хэмжээнд зарцуулалгүй Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ын урьд оны өрийг төлсөн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: “60.3.5 зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах”, Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн

хөгжлийн сангийн зааврын 7.4 дэх заалтад сум өөрийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээтэй тус тус нийцэхгүй байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтын гэрээ, ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Баяндун сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Хайрхан багийн төвийг хашаажуулах” ажлын гэрээний хугацаа дуусаж, гүйцэтгэгч ажлыг гүйцэтгээгүй байхад урьдчилгаа байдлаар олгосон гэрээний үнийн дүнгийн 50 хувь болох 3500,0 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан төлүүлээгүй зардлаар бүртгэсэн байна.
- Баян-Уул сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 15000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Залуус талбайн тохижилт”-ын ажлын даалгаврыг боловсруулахдаа үнийн судалгаа хийгээгүйгээс зах зээлийн үнээс өндөр үнэтэй бараа нийлүүлэгдсэн байна.
- Чулуунхороот сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Бойны цэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тэлэх, засварлах” ажлын 4400,0 мянган төгрөгийн ажил гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон байна.
- Матад сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Мал нядалгааны цехийн тоног төхөөрөмж нийлүүлэх, хашаа бариулах” ажлын гэрээний хугацаа дуусаж, гүйцэтгэгч Батцагаан өргөө ХХК нь ажлыг гүйцэтгээгүй байхад урьдчилгаа байдлаар олгосон гэрээний үнийн дүнгийн 70 хувь болох 56000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан төлүүлээгүй зардлаар бүртгэсэн байна.
- Хэрлэн сумын 8 дугаар багт хийгдсэн 14576,2 мянган төгрөгийн “Тоглоомын талбай байгуулах” хөрөнгө оруулалтын ажил нь чанаргүй хийгдсэн, зарим тоглоомын эд анги байхгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.6 “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

### **III Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

3.1. *ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?* ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавих хяналт хангалтгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавих хороог Баяндун, Баян-Уул, Гурванзагал, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Чойбалсан сумдын ИТХ байгуулсан хэдий ч хяналтын ажлын талаарх ажлын тайлан, баримт байхгүй байгаа нь Сангийн Сайдын

2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйг харуулж байна. Баянтүмэн, Булган, Дашбалбар, Матад, Халхгол, Сэргэлэн, Чулуунхороот, Хэрлэн сум болон аймгийн ИТХ нь 2018 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд хяналт шалгалтын ажлыг хийж хэвшсэн байна.

Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 9.2-д “ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн, хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.” гэж зааснаар санхүүгийн хяналт, аудитын алба нь 2 жилд нэг удаа ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хяналт шалгалтыг хийж байна. Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017, 2018 оны ОНХС-гийн үйл ажиллагаанд 2018.11.25-ны өдрөөс ажлын 30 хоног буюу 2019.01.05-ны дотор багтаан санхүүгийн хяналт шалгалт хийхээр удирдамж гарган ажилласан ч дүгнэлт, тайлан нь бүрэн гараагүй байна.

*3.2. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?* ОНХС-гийн хэрэгжилтийн байдлын тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг сум бүрээр гарган, үр дүнгийн тайланг 2019.03.07-ны 2/445 тоот албан бичгээр Сангийн Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.

## **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох үйлчилгээний зардлыг хэрхэн хуваарилах талаар журам, зааварт тодорхой заасан зохицуулалт байхгүй байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог бүрэн хангаж ажиллаагүй байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг санал аваагүй, хуульд нийцэхгүй арга хэмжээнд төлөвлөж, зарцуулсан байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
5. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг  
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2019.01.08 № 4643

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Дорнод аймагт хэрэгжүүлсэн хөтөрбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлттэй танилцлаа.

Танай байгууллагаас өгсөн зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж, сумын Засаг дарга нарт тавьсан акт, албан шаардлагын биелэлтийг хангуулан ажиллах талаар үүрэг чиглэлийг өгч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА (М) М.БАДАМСҮРЭН



010619191

## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

### **Аймаг, сумдын Засаг дарга нарт:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж ажиллах.
2. Иргэд олон нийтийн саналыг аваагүй, хуульд нийцэхгүй ажилд хөрөнгө зарцуулахгүй байх.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

### **Сумдын ИТХ-ын дарга нарт:**

1. ИТХ-аас Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар нийт 663,4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 123,5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 351.7 сая төгрөгийн 6 албан шаардлага, хариуцлага тооцуулах 27,9 сая төгрөгийн 1 албан шаардлага өгч, 160,3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 12 дугаар сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 12

Холбоотом туг

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор С.Энхбаатар, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор /Б.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

110219020

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга бөгөөд Төргүүлэх аудиторын 2019 оны  
04 дүгээр сарын 10-ны өдрийн  
1/2 дугаар тушаалын хавсралт



Акт, албан шаардлагын жагсаалт

| № | Байгууллагын нэр      | Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар | Мөнгөн дүн /сая төгрөг/ |
|---|-----------------------|----------------------------------------|-------------------------|
| 1 | Булган сум            | 01/49 НАГ-2019/06/-НА                  | 10.0                    |
| 2 | Хөлөнбуйр сум         | 02/50 НАГ-2019/06/-НА                  | 44.9                    |
| 3 | Чулуунхороот сум      | 03/51 НАГ-2019/06/-НА                  | 4.4                     |
| 4 | Баяндун сум           | 04/52 НАГ-2019/06/-НА                  | 5.0                     |
| 5 | Хөлөнбуйр сум         | 05/53 НАГ-2019/06/-НА                  | 3.2                     |
| 6 | Матад сум             | 06/54 НАГ-2019/06/-НА                  | 56.0                    |
|   | <b>дүн</b>            |                                        | <b>123.5</b>            |
| 1 | Гурванзагал сумын ИТХ | 01/81 НАГ-2019/06/-НА                  | 40.6                    |
| 2 | Чойбалсан сумын ИТХ   | 02/82 НАГ-2019/06/-НА                  | 100.2                   |
| 3 | Баяндун сумын ИТХ     | 03/83 НАГ-2019/06/-НА                  | 94.7                    |
| 4 | Цагаан-Овоо сумын ИТХ | 04/84 НАГ-2019/06/-НА                  | 86.7                    |
| 5 | Аймгийн засаг дарга   | 05/91 НАГ-2019/06/-НА                  | 27.9                    |
| 6 | Хэрлэн сум            | 06/109 НАГ-2019/06/-НА                 | 14.5                    |
| 7 | Баян-Уул сум          | 07/110 НАГ-2019/06/-НА                 | 15.0                    |
|   | <b>дүн</b>            |                                        | <b>379.6</b>            |